

ЭРДЭНЭ РЕСУРС ЗУУН МОД МОЛИБДЕН-ЗЭСИЙН ТӨСЛИЙН ХҮДЭРЖИЛТИЙГ ТЭЛЛЭЭ

Онцлох мэдээлэл:

- Газрын гадаргаас 150 метрийн гүн хүртэл гүйцэтгэсэн өрөмдлөгийн үр дүнд өмнө нь хаягдал гэж загварчилсан бүсүүдэд хүдрийн агуулга бүхий хэд хэдэн молибденийн эквивалент (“MoEq”) хүдэржилт огтолсон.
- Тодорхой цооногуудад 6-18 метрийн зузаантай 0.1%-аас дээш MoEq буюу өндөр агуулгатай бүсүүд тогтоогдсон.
- ZMD-98 цооногийг 450 метрийн гүн хүртэл тэлж өрөмдсөн ба цооногийн дийлэнхид молибден ба зэсийн хүдэржилт үргэлжлэн огтолж, нийт 374 метрийн турш 0.066% MoEq агуулга тогтоогдсон.
- 2025 оны өрөмдлөгийн үр дүнг нөөцийн загварыг шинэчлэхэд тусгах бөгөөд 2026 оны дундуур анхан шатны эдийн засгийн тооцооллыг (“PEA”) танилцуулахаар төлөвлөсөн.

Хэвлэлийн мэдээ

Нова Скошиа муж, Халифакс хот

2026.02.17

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (TSX: ERD | OTCQX: ERDCF | MSE: ERDN) (“Эрдэнэ Ресурс” эсвэл “Компани”) нь Монгол Улсын баруун өмнөд бүсэд орших Хөндий Эрдсийн Дүүрэгт, Баянхөндий алтны ордоос зүүн зүгт 35 км-т орших компанийн 100% эзэмшлийн Зуун Мод (“ЗМ”) молибден-зэсийн төслийн өрөмдлөгийн хөтөлбөрийн үр дүн болон техник, эдийн засгийн судалгааны явцын тухай мэдээлэхэд таатай байна. (Зураг 1,2-той танилцана уу.)

Тодруулга

Эрдэнэ Ресурсийн ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал Петер Акерли хэлэхдээ, “Зуун Мод ордод гүйцэтгэсэн өрөмдлөгийн хөтөлбөрийн үр дүн нь газрын гадаргад ойр бүсүүдэд молибденийн хүдэржилт үргэлжилж, агуулга сайжирч буйг баталлаа. Түүнээс гадна, ордын хойд хэсгээр хүдэржилт гүндээ үргэлжилж буйг тогтоосон. Эдгээр үр дүн нь Зуун Мод ордын газрын гадаргад ойр нөөцийг нэмэгдүүлэх боломжтойг харуулсан бөгөөд 2026 оны дундуур танилцуулахаар төлөвлөсөн анхан шатны эдийн засгийн тооцоололд тусгагдана.”

Тэрээр үргэлжлүүлэн, “Хөндий Эрдсийн Дүүргийн дэд бүтэц сайжирч, молибден болон зэсийн эрэлт өндөр байгаа нь Зуун Мод ордыг хөгжүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлж байна. Үүнтэй зэрэгцэн, ижил төрлийн томоохон порфирийн системд хамаарах Хөвийн Хар зэсийн нээлтийн хүрээнд гүний геофизикийн судалгаанд тулгуурлан өрөмдлөгийн зорилтот бүсүүдийг тодорхойлох ажлыг гүйцэтгэж байна.”

Зуун Мод өрөмдлөгийн хөтөлбөр – 2025 оны 4-р улирал

2025 оны сүүлээр Компани өөрийн 100% эзэмшлийн Хөвийн Хар тусгай зөвшөөрлийн талбайд нийт 3,362 тууш метрийн 24 цооног өрөмдсөн. Тус талбай нь Зуун Мод молибден-зэсийн ордыг агуулсан Хөвийн Хар зэсийн порфирийн системийг хамардаг. Хөтөлбөрийн хүрээнд: Зуун Мод ордын газрын гадаргаас эхлэн 150 метрийн гүн хүртэлх хүдэржилтийг шалгах 18 цооног, Хойд Рэйстрак бүсэд молибденийн хүдэржилт гүндээ үргэлжилж буй эсэхийг тодорхойлохоор нэг цооногийг (ZMD-98) гүн рүү тэлж өрөмдсөн. ZMD-98 цооногийн өргөтгөлөөс бусад бүх цооногийг -45° -аас -60° хүртэлх налуу өнцгөөр өрөмдсөн.

Мөн зэсийн порфирийн бүсүүдийг шалгах зорилгоор 2 цооног (ZMD-162 ба 163) ([Хэвлэлийн мэдээтэй](#) танилцана уу), Зуун Мод ордоос баруун зүгт 3.8 км-т орших алтны хэтийн төлөв бүхий бүсийг шалгахаар гурван хайгуулын цооног өрөмдсөн. Энэхүү өрөмдлөгийн хөтөлбөрийн үр дүнг шинэчилсэн нөөцийн тооцоололд тусган, 2026 оны дундуур танилцуулахаар төлөвлөж буй Анхан шатны эдийн засгийн тооцооллын суурь болгон ашиглана.

Газрын гадаргад ойр гүйцэтгэсэн өрөмдлөгөөр босоо чиглэлд 130 метр хүртэл гүнд өндөр агуулга бүхий молибден, зэсийн хүдэржилтийг огтолсон. Хэд хэдэн цооногт 112 метр хүртэлх гүнд 0.07% молибденийн эквивалент (“MoEq”) агуулга бүхий интервал огтолсон ба зарим цооног нь хүдэржилтээр төгссөн. Энэ нь хүдэржилт босоо болон дэд хэвтээ чиглэлд үргэлжилж буйг баталж, өмнө нь бага агуулгатай эсвэл хүдэржилтгүй хэмээн загварчилсан бүсүүдийг нөхөн тодорхойлсноор шинэчилсэн нөөцийн загварыг баталгаажууллаа.

Ордын хойд хэсэгт, харьцангуй бага судалгаа хийсэн талбайд өрөмдсөн ZMD-98 өргөтгөлийн цооног нь дийлэнх хэсэгт молибден, зэсийн хүдэржилт огтолж, 450 метрийн гүнд хүдэржилтээр төгссөн. Өмнө мэдээлсэн үр дүнтэй нэгтгэн үзвэл, энэхүү цооног нь Хойд Рэйстрак бүсийн төв хэсэгт 0.066% молибденийн эквивалент агуулга бүхий 374 метрийн (76-аас 450 метр) интервал огтолсон. Энэхүү өндөр агуулгатай бүс нь босоо болон хажуу чиглэлд нээлттэй байгаа тул цаашдын өрөмдлөгийг голлон энэ бүсэд чиглүүлэхээр төлөвлөж байна.

Дээрх үр дүнгүүдийг цогцоор нь авч үзвэл, 2025 оны 10-р сард мэдээлсэн ([Хэвлэлийн мэдээтэй](#) танилцана уу) нөөцийн шинэчлэлд суурилан, төслийн эрдсийн нөөцийг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлэх хүлээлттэй байна. Онцлох сорьцын шинжилгээний үр дүнг Хүснэгт 1-т хураангуйлан үзүүлэв.

Хүснэгт 1 - Сорьцын шинжилгээний үр дүнгийн хураангуй – Зуун Мод молибден-зэсийн орд

Цооног	М-ээс	М хүртэл	Зузаан (м)	Cu %	Mo %	MoEq % ⁽³⁾
ZMD-98 ⁽¹⁾	76	450 ⁽²⁾	374	0.058	0.050	0.066
үүнд	324	338	14	0.096	0.121	0.147
үүнд	408	426	18	0.094	0.113	0.139
ZMD-143T	40	74	34	0.048	0.043	0.056
ZMD-145T	76	126	50	0.061	0.050	0.067
ZMD-146T	71	84	13	0.038	0.059	0.070
ZMD-147	124	140 ⁽²⁾	16	0.131	0.100	0.136
ZMD-148	100	140 ⁽²⁾	40	0.050	0.055	0.068
ZMD-149	76	94	18	0.036	0.033	0.043
ZMD-150	94	122	28	0.028	0.072	0.079
ZMD-151	36	122	86	0.040	0.056	0.066
үүнд	78	88	10	0.035	0.111	0.120
ба	136	142	6	0.056	0.084	0.099
ZMD-152	112	130 ⁽²⁾	18	0.078	0.043	0.064
ZMD-153	38	130 ⁽²⁾	92	0.051	0.058	0.072
үүнд	84	102	18	0.061	0.112	0.128
ZMD-154	72	110	38	0.074	0.058	0.078
үүнд	80	88	8	0.111	0.136	0.166
ZMD-155	70	110	40	0.044	0.050	0.062
ZMD-156	8	120 ⁽²⁾	112	0.063	0.055	0.072
үүнд	86	98	12	0.074	0.112	0.133
ZMD-157	84	125 ⁽²⁾	41	0.070	0.052	0.071
ZMD-159	20	40	20	0.051	0.046	0.060
ZMD-161	50	78	28	0.049	0.062	0.075
үүнд	50	56	6	0.047	0.117	0.130

(1) ZMD-98 цооногийг 150 метрээс 450 метр хүртэл сунгасан, 0-оос 150м хүртэл мэдээллийг өмнө нь тайлагнасан.

(2) Цооног хүдэржилтээр төгссөн

(3) MoEq%=Mo% + Cu% * 0.27504 ба 83% Mo болон 81% Cu металл авалттайгаар тооцож, молибденийн үнийг нэг фунт US\$15.4, зэсийн үнийг нэг фунт нь US\$4.34 байхаар тооцоолсон.

Зуун Мод – Анхан шатны эдийн засгийн тооцоолол

Зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал болон молибден, зэсийн урт хугацааны төлөвийг харгалзан Компани нь Зуун Мод төслийн Анхан шатны эдийн засгийн тооцооллыг (“PEA”-Preliminary Economic Assessment) эхлүүлээд байна. Дээр дурдсан өрөмдлөгийн хөтөлбөрийн үр дүнг 2026 оны 1-р улиралд нөөцийн шинэчилсэн загварт тусгаж, улмаар оновчлол, урьдчилсан загварчлал, техник тоног

төхөөрөмжийн сонголт, олборлолтын хуваарь зэрэг судалгааны ажлуудыг шат дараатайгаар гүйцэтгэнэ.

Металл авалтын суурь таамаглалуудыг баталгаажуулах зорилгоор ордын хэд хэдэн бүсэд металлургийн туршилт, судалгааг хийхээр төлөвлөсөн. Түүнчлэн Баянхөндий уурхайн хүрээнд болон дүүргийн орчимд хэрэгжиж буй уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой дэд бүтцийн хөгжил нь Зуун Мод төслийн хэрэгжилтэд эергээр нөлөөлөх хүлээлттэй байна. Үүнд: тээвэр ложистик, гэрээт гүйцэтгэгч, ханган нийлүүлэлт болон ажиллах хүчний нөөц зэрэг хүчин зүйлс багтана. Байгаль орчны болон зөвшөөрлийн судалгааны ажлуудыг энэ онд зардлын тооцоолол, санхүүгийн загварчлалтай уялдуулан гүйцэтгэх бөгөөд Анхан шатны эдийн засгийн тооцооллыг 2026 оны 3-р улиралд эцэслэхээр төлөвлөсөн.

Хөвийн Хар өрөмдлөгийн хөтөлбөр

Хөвийн Хар зэсийн порфирийн цогцолборын хойд хэсэгт гидротермаль хувиралттай интрузив нэгжүүд болон брекчүүдээс бүрэх, ойролцоогоор 20 км² талбайг хамарсан томоохон бүсэд тархсан зэсийн хүдэржилтийг тогтоосон. Хөвийн Хар талбайд илэрсэн зэсийн хүдэржилтийн интервалууд нь гидротермаль хувиралттай интрузив брекч, калийн хувирал болон хүдэржсэн хэлтэрхий агуулж байгаа нь гүндээ хүдэржилтийн эх үүсвэр байгааг илтгэж байна. Хамгийн өндөр агуулгатай зэсийн хүдэржилтийг 2026 оны 1-р сард тайлагнасан бөгөөд энэ нь 2010 оны сүүлээр өрөмдсөн ZMD-121 цооногт огтолсон хүдэржилтийг тэлж шалгах зорилгоор өрөмдсөн ZMD-162 цооногоос илэрсэн.

ZMD-162 цооногт 0.63% зэс болон 2.9 г/т мөнгөний агуулга бүхий 65 метрийн интервал огтолсон ба үүнд 1.25% зэс, 6.1 г/т мөнгөний агуулга бүхий 30 метрийн интервал багтаж байна.

Хоёр дахь цооног болох ZMD-163-ийг ZMD-162 цооногоос хойд зүгт газрын гадаргад ойр байрлах хувирлын бүсийг шалгахаар өрөмдсөн ба аномаль зэсийн хүдэржилт бүхий өргөн бүсүүдийг огтолсон. Үүнд: 0.1% зэсийн агуулга бүхий 24 метрийн интервал багтсан бөгөөд аномаль зэсийн хүдэржилтээр төгссөн.

Хөвийн Хар хэтийн төлөв бүхий талбайн зэсийн порфирийн боломжийг цаашид бүрэн үнэлэхийн тулд нэмэлт өрөмдлөг шаардлагатай гэж үзэж байна. Үүнтэй уялдуулан Хөвийн Хар порфирийн системийг нарийвчлан тодорхойлох, цаашдын өрөмдлөгийн зорилтот бүсүүдийг тооцоолох зорилгоор гүний геофизикийн судалгааны хөтөлбөр боловсруулж байна.

Хүснэгт 2 – Сорьцын шинжилгээний үр дүнгийн хураангуй – Хөвийн Хар зэсийн талбай

Цооног	М-ээс	М хүртэл	Зузаан (м)	Cu %	Ag г/т
ZMD-162	286	351	65	0.630	2.900
үүнд	298	328	30	1.250	6.100
ZMD-163	8	104	96	0.074	-
үүнд	24	48	24	0.106	-
ба	122	200 ⁽¹⁾	78	0.049	-

(1) Цооногийн төгсгөл

Жаргах Наран алтны хэтийн төлөв бүхий талбай

Жаргах Наран алтны хэтийн төлөв бүхий талбай (“Prospect”) нь Хөвийн Хар тусгай зөвшөөрлийн талбайд, Зуун Мод молибден-зэсийн ордоос баруун зүгт 3.8 км-т байрладаг. Тус талбайд зүүн-баруун чиглэлтэй исэлдсэн кварцын нарийн судлууд цувран тархсан бөгөөд 100 метр хүртэлх суналын уртаар зураглагдсан. Эрдэнэ Ресурсийн гүйцэтгэсэн гадаргын сорьцлолын үр дүнд 5.5 г/т хүртэлх алтны агуулга тогтоогдсон.

2025 оны 12 сард (ZMD-164, 165 ба 166) тус тусдаа зорилтот гурван бүсийг шалгах аар ойролцоогоор 100 метрийн зайтай байрлуулсан гурван хайгуулын цооног өрөмдсөн. Эдгээрээс хоёр цооног буюу ZMD-164 ба ZMD-165 нь газрын гадаргаас эхлэн цооногийн бараг бүх уртаар алтны аномаль өндөр утгуудыг тасралтгүй огтолсон. Үүнд: ZMD-164 цооногт 0.19 г/т алтны агуулга бүхий 5 метрийг багтаасан 28 метрийн зузаан монзонит порфирийг огтолсон нарийн ширхэгтэй сульфид болон цахиурлаг судлуудаас тогтсон штокверк бүс багтаж байна.

ZMD-165 цооногт мөн адил ZMD-164-т огтолсон ижил төрлийн штокверк судал бүхий монзонит порфирийн нэгжийг огтолсон ба 0.20 г/т алтны агуулга бүхий 4 метр, 0.27 г/т агуулга бүхий 3 метр багтаж байна.

Зуун Мод Молибден-зэсийн төслийн тухай

Зуун Мод молибден-зэсийн төсөл нь дэлхийн хамгийн том зэс, молибденийн хэрэглэгч, мөн гангийн тэргүүлэх үйлдвэрлэгч болох БНХАУ-ын хилийн боомт болон Монгол Улсын томоохон уул уурхайн дүүргээс баруун хойд зүгт ойролцоогоор 180 км-т, Баянхонгор аймгийн нутаг дэвсгэрт байрладаг. Компанийн 100% эзэмшлийн ашиглалтын тусгай зөвшөөрөл нь 6,041 га талбайг хамардаг бөгөөд 60 жилийн хугацаанд хүчинтэй (2011 онд олгогдсон). Тус төсөл нь Эрдэнэ Ресурсийн Баян Хөндий алтны төслөөс зүүн тийш 35 км-т оршдог.

Эрдэнэ Ресурс нь олон жилийн хайгуулын хөтөлбөрөөр Зуун Мод молибден-зэсийн ордын хил зааг, түүнчлэн зэс, молибденийн хэтийн төлөв бүхий хэд хэдэн талбайг тодорхойлсон нь 16 км радиус бүхий порфирийн цогц системд багтдаг. Өнгөрсөн жилүүдэд компани алтны төслүүдэд төвлөрч ажилласантай холбоотойгоор ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2011 онд авснаас хойш Хөвийн Хар талбайд хайгуул болон техникийн судалгааны ажлууд харьцангуй хязгаарлагдмал хэмжээнд хийсэн.

2025 оны 10-р сард Эрдэнэ Ресурс нь Зуун Мод молибден-зэсийн ордын шинэчилсэн нөөцийн тооцооллыг танилцуулсан. Шинэчилсэн нөөцийн тооцооллоор 0.056% молибден, 0.064% зэсийн агуулга (0.073% молибден эквивалент (“MoEq”)) бүхий 271.1 сая тонн буюу 439.2 сая фунт (“Mlbs”) баттай болон бодитой нөөц тооцоолсон. Мөн 0.051% молибден, 0.059% зэсийн агуулга (0.070% молибден эквивалент (“MoEq”)) бүхий 269.1 сая тонн буюу 416.3 сая фунт (“Mlbs”) боломжтой нөөц тооцоолсон. Уурхайн оновчлолыг 0.035% дээш молибденийн захын агуулгаар, молибденийн үнийг US\$22/фунтээр тооцон, тайлагнасан. Мо-ийн эквивалент (MoEq)-ийг дараах томъёогоор тооцсон: $MoEq\% = Mo\% + Cu\% * 0.27504$, металл

авалтыг Mo- 83%, Cu- 81%-иар тооцоолсон. Дэлгэрэнгүй мэдээлэлтэй компанийн 2025 оны 10 сарын 10-ны хэвлэлийн мэдээнээс танилцана уу.

Мэргэшсэн этгээд (геологич)

Петер Далтон (Peter Dalton) нь Компанийн ахлах геологич (P.Geo, Nova Scotia) бөгөөд NI 43-101-т заасан мэргэшсэн этгээд ба хэвлэлийн мэдээ дэх техникийн мэдээллийг Эрдэнэ Ресурсийн зүгээс хянан баталгаажуулсан болно. Бүх дээжийг Улаанбаатар хот дахь Эс Жи Эс ("SGS") лабораторид шинжлүүлсэн. Эс Жи Эс лабораторийн дотоод хяналт шалгалтаас гадна, Компани нь тусгай стандарт бэлдэц, хээрийн болон лабораторийн хуулбар, мөн хүдэржилтгүй бэлдцийг ашиглан дээжийн чанарын хяналт, баталгаажуулалт ("QA/QC")-ын протоколыг гүйцэтгэсэн. Бүх дээжид олон төрлийн элементийн агуулгыг Индукцын хос плазмет спектрометрийн арга (Inductively Coupled Plasma Optical Emission Spectroscopy) ашиглан тогтоосон.

Эрдэнэ Ресурсийн дээжлэлтийн протокол нь зарим нэг жижиг, хүдэржилтийн дараа үеийн чулуулаг болон хүдэржилтгүй боржинг алгассан, 1 эсвэл 2 метрийн интервалтайгаар, цооногийг бүтнээр нь хамарсан дээжлэлтээс бүрддэг. Дээжлэлтийн интервалыг чөмгөн дээжний гүний метр дээр үндэслэдэг ба геологийн хяналт эсвэл хүдэржилтээс хамаардаггүй болно. Бүх дээжийг чөмгөн дээжний гүний метр дээр үндэслэн алмазан хөрөөгөөр 2 тэнцүү хуваадаг. Хуваагдсан дээжийн талыг дээжний уутанд ялган авч дээжилдэг бөгөөд үлдсэн талыг нь дээжний хайрцагт үлдээн Компанийн Баянхөндий дэх хээрийн ангид аюулгүй байдлыг ханган хадгалдаг. Бүх дээжийг нэг багцандаа 30 дээж байхаар хуваарилдаг ба багц болгонд стандарт бэлдэц, хүдэржилтгүй бэлдэц, лабораторийн хуулбар болон хээрийн хуулбар дээж буюу дээжийг 4 хуваан, 2-ыг нь 2 тусад нь дээжлэн Улаанбаатар дахь Эс Жи Эс ("SGS") лаборатори руу тээвэрлэдэг.

Тайлагнасан интервал нь бодит зузаан бөгөөд өөрөөр хэлбэл цооногийн өргөн юм. Зуун Модын өрөмдлөгийн цооногуудыг 70 градусын уналаар өрөмдсөн. Бодит өргөнийг баталгаажуулахын тулд нэмэлт судалгаа хийх шаардлагатай. Интервалуудын тайлагнасан агуулга нь түүвэр интервалын уртад үндэслэсэн жигнэсэн дундаж үзүүлэлтүүд юм. Дээд хязгаарлалт хийгээгүй.

Компанийн тухай

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Баянхөндий алтны төслийг олборлолтын шат руу хөгжүүлэхээс гадна Монгол Улсад суурь болон үнэт металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад Улсад бүртгэлтэй хайгуулын компани. Компани нь Хөндий Эрдсийн Дүүрэгт Баянхөндий алтны төслийн орчимд хэд хэдэн үнэт болон суурь металлын төслүүдийн хувь эзэмшдэг. Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Торонто (TSX:ERD) болон Монголын хөрөнгийн биржүүд (MSE:ERDN) ба OTCQX зах зээлд (OTCQX:ERDCF) бүртгэлтэй. Компанийн тухай дэлгэрэнгүй мэдээлэлтэй Компанийн вебсайт www.erdene.com-оос танилцах боломжтой. Компанийн талаарх чухал мэдээллүүд нь зөвхөн Компанийн вебсайтаар дамжин хүрдэг тул хөрөнгө оруулагчид вебсайтаар дамжуулан бодит мэдээлэл авахыг зөвлөж байна.

Урьдчилсан таамаглал

Зарим мэдээллүүд нь Үнэт цаасны хуулийн хүрээнд урьдчилсан таамаглалуудыг агуулсан болохыг үүгээр мэдэгдэж байна. Урьдчилсан таамаглал нь урьд болж байсан болон ирээдүйд болох бодит баримт биш ба зөвхөн ирээдүйн төлөвлөгөө, стратеги, төсөл, нөхцөл байдалд тулгуурласан үзэл баримтлал, магадлал болон таамаглал болно. Энэхүү таамаглалууд нь тодорхой үндэслэлд тулгуурласан боловч баталгаа биш юм. Компанийн үйл ажиллагаа нь олон хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд зарим хүчин зүйлс нь Компанийн хяналтаас давсан байх магадлалтай ирээдүйд учирч болох хүчин зүйлс юм. Материаллаг өөрчлөлт үзүүлэх боломжтой хүчин зүйлсэд эрдсийн зах зээлийн үнэ, хайгуулын үр дүнгүүд, бизнесийн болон зах зээлийн орчин, эдийн засгийн байдал болон санхүүжилт, хөрөнгө босголт зэрэг орно. Дээр дурдсан мэдээллүүд нь ирээдүйд өөрчлөгдөн хувирах магадлалтай. Компани нь Үнэт цаасны хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд Урьдчилсан таамаглалыг өөрчлөн, шинэчлэх үүрэг хүлээхгүй.

Энэхүү хэвлэлийн мэдээ нь англи хэл дээр бэлтгэгдсэн хэвлэлийн мэдээний орчуулга болно. Англи, монгол хувилбаруудын хооронд зөрүү эсвэл зөрчилдөх зүйл гарвал англи хэл дээрх хувийг мөрдөнө.

ЭНЭХҮҮ МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХАД ЯМАРВАА НЭГЭН ЗАСАГ ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ЗӨВШӨӨРСӨН, ҮЛ ЗӨВШӨӨРСӨН МЭДЭГДЭЛ ХИЙГЭЭГҮЙ.

Холбоо барих:

Петер К. Акерли, Ерөнхийлөгч болон гүйцэтгэх захирал

Роберт Женкинс, Санхүү хариуцсан захирал

Утас: (902) 423-6419

И-мэйл: info@erdene.com

Twitter: <https://twitter.com/ErdeneRes>


Facebook: <https://www.facebook.com/ErdeneResource>

LinkedIn: <https://www.linkedin.com/company/erdene-resource-development-corp-/>

ZUUN MOD MOLYBDENUM PROJECT – KHUNDII MINERALS DISTRICT


Located in a Growing Mining Region Less Than 200km from the Chinese Border





Zuun Mod Deposit	Tonnage	Mo Grade	Cu Grade	MoEq	Contained Mo	Contained Cu	MoEq
Classification	Mt	%	%	%	Mlbs	Mlbs	Mlbs
Measured	45.8	0.057	0.062	0.074	57.7	62.2	74.8
Indicated	225.3	0.056	0.065	0.073	275.9	322.0	364.4
M&I	271.1	0.056	0.064	0.073	333.5	384.2	439.2
Inferred	269.1	0.051	0.059	0.070	300.0	350.7	416.3

ZUUN MOD – Q4 2025 DRILL PROGRAM HIGHLIGHTS



Hole ID	From (m)	To (m)	Width	Cu%	Mo%	MoEq % ⁽¹⁾	
ZMD – 98 (ALL)	76	450	EOH	374	0.058	0.050	0.066
ZMD – 98 Ext	180	450	EOH	270	0.063	0.056	0.073
Incl	324	338		14	0.096	0.121	0.147
Inc	408	426		18	0.094	0.113	0.139
ZMD – 143T	40	74		34	0.048	0.043	0.056
ZMD – 145T	76	126		50	0.061	0.050	0.067
ZMD – 146T	71	84		13	0.038	0.059	0.070
ZMD – 147	124	140	EOH	16	0.131	0.100	0.136
ZMD – 148	100	140	EOH	40	0.050	0.055	0.068
ZMD – 149	76	94		18	0.036	0.033	0.043
ZMD – 150	94	122		28	0.028	0.072	0.079
ZMD – 151	36	122		86	0.040	0.056	0.066
incl	78	88		10	0.035	0.111	0.120
and	136	142		6	0.056	0.084	0.099
ZMD – 152	112	130	EOH	18	0.078	0.043	0.064
ZMD – 153	38	130	EOH	92	0.051	0.058	0.072
incl	84	102		18	0.061	0.112	0.128
ZMD – 154	72	110		38	0.074	0.058	0.078
incl	80	88		8	0.111	0.136	0.166
ZMD – 155	70	110		40	0.044	0.050	0.062
ZMD – 156	8	120	EOH	112	0.063	0.055	0.072
incl	86	98		12	0.074	0.112	0.133
ZMD – 157	84	125	EOH	41	0.070	0.052	0.071
ZMD – 158	No significant mineralization						
ZMD – 159	20	40		20	0.051	0.046	0.060
ZMD – 160	No significant mineralization						
ZMD – 161	50	78		28	0.049	0.062	0.075
incl	50	56		6	0.047	0.117	0.130

DEFINING NEAR SURFACE HIGH-GRADE MOLYBDENUM RESOURCES

Zuun Mod – North Racetrack Section 1

